

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/304/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар.....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага.....	25
5.3 Зөвлөмж	30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЦХИХХС	Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайд
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТББ	Төрийн бус байгууллага
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МЯГМАРНАРАН
ТАНАА

2026.02.25 № 06/289

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 1,036,447.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 298,419.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Азийн хөгжлийн банктай байгуулсан "техникийн туслалцааны хөтөлбөр" төслийн хүрээнд яамны данс бүртгэлд шилжиж ирсэн 248,717.3 мянган төгрөгийн хөрөнгийг 7 аймгийн Засаг даргын Тамгын газруудад шилжүүлсэн нь нотлох баримтаар дэмжигдээгүй;
- Урамшуулал давхардуулан олгосон, илүү цагийн цалин хөлстэй холбоотой нийт 151,768.5 мянган төгрөг;
- Төсөвт батлагдаагүй арга хэмжээг зохион байгуулах, инновацийг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулах судалгааны ажилд 118,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1, 6.4.8, 12 дугаар зүйлийн 12.1.11, 16 дугаар зүйлийн 16.5.5, 22 дугаар зүйлийн 22.2.3-22.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 4.1.9, 15 дугаар зүйлийн 15.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дах заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого", Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгавраар их өгөгдөл, хиймэл оюун ухааны үндэсний стратеги боловсруулж, хэрэгжүүлэх аргачлалыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх үүргийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад даалгасан.

Тус албан даалгаврын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны яам Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй хамтран 406,729.4 мянган төгрөгийн гэрээ байгуулан, санхүүжилтийг олгож "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг боловсруулан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны хязгаар тогтоох тухай" 07 дугаар тогтоолын дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 тоот тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулан 89 болгон баталсан байна.

Бүтцийн шинэчлэлээр 8 газар, 9 хэлтэс, нийт орон тоо 98 байсныг 5 газар, 5 хэлтэс болгон удирдах 7 албан тушаалтан, гүйцэтгэх 2 албан тушаалтныг цомхотгон 89 орон тоотойгоор батлагдсан, гүйцэтгэлээр тайлант онд 73 орон тоотойгоор ажилласан байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. А. Ц. НАРАНЧИМЭГ*



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	752,091,499.40	1,259,527,095.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,181.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,181.00	-
31210	Төгрөг	30,181.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	30,181.00	-
33	АВЛАГА	31,694,513.40	15,771,631.00
33500	Бусад авлага	31,694,513.40	15,771,631.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	31,694,513.40	15,771,631.00
34	УРЬДЧИЛГАА	236,116,020.00	312,477,900.00
34600	Урьдчилж гарсан зардал	236,116,020.00	312,477,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	294,443,035.00	910,485,364.00
35400	Хангамжийн материал	294,443,035.00	910,485,364.00
35410	Бичиг хэргийн материал	12,984,120.00	9,674,080.00
35420	Аж ахуйн материал	111,256,440.80	112,351,109.80
35430	Сэлбэг хэрэгсэл	46,693,400.00	46,190,900.00
35450	Барилгын засварын материал	6,643,700.00	6,599,700.00
35470	Бусад хангамжийн материал	116,865,374.20	735,669,574.20
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	189,807,750.00	20,792,200.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	189,807,750.00	20,792,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,462,624,611.26	2,539,851,354.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,462,624,611.26	2,539,851,354.80
39200	Биет хөрөнгө	551,067,741.23	611,706,966.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	223,753,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,486,154.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,750,000.00)	(5,750,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,343,633,360.78	1,189,410,067.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(997,324,993.45)	(931,318,061.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	421,287,537.55	382,150,007.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(219,778,163.65)	(250,052,792.88)
39300	Биет бус хөрөнгө	2,911,556,870.03	1,928,144,388.68
39301	Програм хангамж	3,850,739,343.60	3,853,208,843.60
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,042,032,473.59)	(2,097,330,294.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	948,310,000.00	878,775,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(845,459,999.98)	(706,510,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,214,716,110.66	3,799,378,449.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,308,492,450.00	1,628,630,788.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,308,492,450.00	1,628,630,788.00
41300	Өглөг	1,308,492,450.00	1,628,630,788.00
41360	Бусад өглөг	1,308,492,450.00	1,628,630,788.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,308,492,450.00	1,617,855,950.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	10,774,838.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,906,223,660.66	2,170,747,661.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,906,223,660.66	2,170,747,661.80
51200	Хуримтлагдсан үр дүн	2,906,223,660.66	2,170,747,661.80
51210	Өмнөх үеийн үр дүн	1,818,868,174.01	2,946,637,668.86
51220	Тайлант үеийн үр дүн	1,087,355,486.65	(775,890,007.06)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,214,716,110.66	3,799,378,449.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	25,162,677,548.62	15,948,791,004.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,082,144.62	15,948,791,004.27
120	Нийтлэг татварын бус орлого	86,082,144.62	522,723,504.27
120009	Бусад орлого	54,638,680.98	36,717,489.27
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31,443,463.64	237,288,740.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	248,717,275.00
122	Тусламжийн орлого	-	15,426,067,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	15,426,067,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	15,426,057,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	15,426,057,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,900.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,076,595,404.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	22,486,794,340.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,486,794,340.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,589,608,478.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,549,608,478.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	192,586.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	192,586.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,279,763,450.93	16,230,930,986.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,279,763,450.93	16,230,930,986.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,238,679,852.42	6,842,869,096.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,285,714,748.88	3,325,664,844.36
210101	Үндсэн цалин	2,150,132,764.98	2,202,568,961.84
210102	Нэмэгдэл	486,689,483.90	496,064,973.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	380,111,000.00	475,131,000.00
210104	Урамшуулал	268,781,500.00	151,899,909.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	411,591,111.63	424,395,944.27
210201	Тэтгэврийн даатгалын зардал	281,561,217.14	291,771,658.16
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	33,271,037.56	34,422,710.30
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	16,707,567.39	16,941,371.53
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,215,460.71	16,289,121.39
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	63,835,828.83	64,971,082.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,736,618.38	104,901,124.38
210301	Гэрэл, цахилгаан	31,538,238.47	43,892,909.80
210302	Түлш, халаалт	39,048,283.91	50,959,488.58
210303	Цэвэр, бохир ус	7,950,096.00	10,048,726.00
210304	Байрны түрээс	16,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	137,817,494.44	111,056,729.00
210401	Бичиг хэрэг	38,092,110.00	28,572,840.00
210402	Тээвэр, шатахуун	5,852,286.00	817,380.00

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,503,438.44	42,323,488.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	3,098,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,324,970.00	33,806,330.00
210408	Бараа материал акталсны зардал	29,384,690.00	2,438,371.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,966,650.00	7,400,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	759,850.00	-
210604	Урсгал засвар	19,206,800.00	7,400,400.00
2107	Томилолт, зочны зардал	172,556,041.60	73,651,685.40
210701	Гадаад албан томилолт	135,688,190.60	38,383,855.40
210702	Дотоод албан томилолт	36,022,301.00	35,267,830.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	845,550.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,977,535,916.60	461,640,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,958,881,293.60	455,089,321.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,523.00	344,469.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,240,000.00	5,325,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,319,100.00	860,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,138,761,270.89	2,334,157,578.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,097,339,498.00	822,736,293.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,970,000.00	46,940,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,032,451,772.89	1,464,481,285.74
212	ТАТААС	7,934,196,200.00	6,570,000,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,434,196,200.00	5,220,000,000.00
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,434,196,200.00	5,220,000,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,500,000,000.00	1,350,000,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,500,000,000.00	1,350,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,106,887,398.51	2,818,061,890.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,487,356,414.47	2,737,726,890.19
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	877,095,016.19
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	877,095,016.19
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	877,085,116.19
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	9,900.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,487,356,414.47	1,860,631,874.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	267,231,800.00	80,335,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,081,800.00	15,535,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,150,000.00	64,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	182,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,352,299,184.04	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,352,299,184.04	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,882,914,097.69	(282,139,982.07)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	795,558,611.04	493,750,024.99
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	32,211.04	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	55,224,999.99

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	795,526,400.00	438,525,025.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(795,558,611.04)	(493,750,024.99)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,087,355,486.65	(775,890,007.06)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	25,076,595,404.00	15,426,067,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,586.00	15,426,067,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	192,586.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	192,586.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	192,586.00	-
122	Тусламжийн орлого	-	15,426,067,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	15,426,067,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	15,426,057,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	15,426,057,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,900.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,076,402,818.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	22,486,794,340.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,486,794,340.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,589,608,478.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,549,608,478.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,893,728,560.40	15,325,901,881.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,893,728,560.40	15,325,901,881.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,057,438,991.13	6,138,578,510.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,290,157,679.88	3,323,176,006.36
210101	Үндсэн цалин	2,155,516,527.87	2,201,817,944.79
210102	Нэмэгдэл	486,706,138.45	499,009,234.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	379,423,112.02	471,437,417.52
210104	Урамшуулал	268,511,901.54	150,911,409.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	409,591,111.63	424,395,944.27
210201	Тэтгэврийн даатгалын зардал	281,561,217.14	291,771,658.16
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	33,271,037.56	34,422,710.30
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	15,245,736.90	16,941,371.53
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	15,677,291.20	16,289,121.39
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	63,835,828.83	64,971,082.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,736,618.38	104,901,124.38
210301	Гэрэл, цахилгаан	31,538,238.47	43,892,909.80
210302	Түлш, халаалт	39,048,283.91	50,959,488.58
210303	Цэвэр, бохир ус	7,950,096.00	10,048,726.00

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	16,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	106,827,453.44	102,924,358.00
210401	Бичиг хэрэг	34,167,860.00	21,190,220.00
210402	Тээвэр, шатахуун	8,873,360.00	817,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,503,438.44	42,323,488.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	3,098,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,622,795.00	35,494,950.00
2105	Нормативт зардал	-	17,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	17,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,466,900.00	31,654,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,724,800.00	22,778,200.00
210604	Урсгал засвар	20,742,100.00	8,876,700.00
2107	Томилолт, зочны зардал	147,627,667.00	59,295,063.80
210701	Гадаад албан томилолт	103,985,366.00	29,265,063.80
210702	Дотоод албан томилолт	43,642,301.00	30,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,720,329,529.40	920,156,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,906,243.60	872,589,321.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,523.00	344,469.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,103,762.80	46,484,440.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,224,000.00	716,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,219,702,031.40	1,154,574,884.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,210,732,031.40	1,107,634,884.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,970,000.00	46,940,000.00
212	ТАТААС	7,934,196,200.00	6,554,987,500.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,434,196,200.00	5,208,072,300.00
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,434,196,200.00	5,208,072,300.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,500,000,000.00	1,346,915,200.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,500,000,000.00	1,346,915,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,902,093,369.27	2,632,335,870.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,282,562,385.23	2,560,286,870.19
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	877,095,016.19
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	877,095,016.19
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	877,085,116.19
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	9,900.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,282,562,385.23	1,683,191,854.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	267,231,800.00	72,049,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,081,800.00	7,249,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,150,000.00	64,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	182,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,352,299,184.04	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,352,299,184.04	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,182,866,843.60	100,165,619.00

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,182,876,843.60	100,195,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,182,876,843.60	100,195,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,182,876,843.60	100,195,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,182,876,843.60	100,195,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,182,876,843.60)	(100,195,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(10,000.00)	(30,181.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,181.00	30,181.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,181.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,818,868,174.01	1,818,868,174.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,818,868,174.01	1,818,868,174.01
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,087,355,486.65	1,087,355,486.65
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,906,223,660.66	2,906,223,660.66
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	40,414,008.20	40,414,008.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,946,637,668.86	2,946,637,668.86
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(775,890,007.06)	(775,890,007.06)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,170,747,661.80	2,170,747,661.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
Татварын бус орлого	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
Тусламжийн орлого	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
Төсвөөс санхүүжих	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
УРСГАЛ ЗАРДАЛ	16,698,762,200.00	14,548,972,483.81	2,149,789,716.19	87.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,894,929,800.00	6,238,744,129.81	1,656,185,670.19	79.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,899,122,600.00	3,323,176,006.36	575,946,593.64	85.2
Үндсэн цалин	2,172,531,400.00	2,201,817,944.79	(29,286,544.79)	101.3
Нэмэгдэл	869,957,100.00	499,009,234.75	370,947,865.25	57.4
Унаа хоолны хөнгөлөлт	466,028,600.00	471,437,417.52	(5,408,817.52)	101.2
Урамшуулал	390,605,500.00	150,911,409.30	239,694,090.70	38.6

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	523,586,300.00	424,395,944.27	99,190,355.73	81.1
Тэтгэврийн даатгал	355,075,300.00	291,771,658.16	63,303,641.84	82.2
Тэтгэмжийн даатгал	42,161,300.00	34,422,710.30	7,738,589.70	81.6
ҮОМШӨ-ний даатгал	21,066,100.00	16,941,371.53	4,124,728.47	80.4
Ажилгүйдлийн даатгал	21,056,000.00	16,289,121.39	4,766,878.61	77.4
Эрүүл мэндийн даатгал	84,227,600.00	64,971,082.89	19,256,517.11	77.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,957,900.00	104,901,124.38	37,056,775.62	73.9
Гэрэл, цахилгаан	78,749,200.00	43,892,909.80	34,856,290.20	55.7
Түлш, халаалт	40,102,300.00	50,959,488.58	(10,857,188.58)	127.1
Цэвэр, бохир ус	9,155,500.00	10,048,726.00	(893,226.00)	109.8
Байрны түрээс	13,950,900.00	-	13,950,900.00	-
Хангамж, бараа материалын зардал	151,163,900.00	102,924,358.00	48,239,542.00	68.1
Бичиг хэрэг	23,166,700.00	21,190,220.00	1,976,480.00	91.5
Тээвэр, шатахуун	817,400.00	817,380.00	20.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,374,400.00	42,323,488.00	9,050,912.00	82.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,208,200.00	3,098,320.00	4,109,880.00	43.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,597,200.00	35,494,950.00	33,102,250.00	51.7
Нормативт зардал	17,500,000.00	17,500,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,500,000.00	17,500,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	133,679,100.00	131,850,700.00	1,828,400.00	98.6
Багаж, техник, хэрэгсэл	122,974,100.00	122,974,000.00	100.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,828,300.00	-	1,828,300.00	-
Урсгал засвар	8,876,700.00	8,876,700.00	-	100.0
Томилолт, зочны зардал	60,119,500.00	59,295,063.80	824,436.20	98.6
Гадаад албан томилолт	30,089,500.00	29,265,063.80	824,436.20	97.3
Дотоод албан томилолт	30,030,000.00	30,030,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,218,666,100.00	920,126,049.00	298,540,051.00	75.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,142,501,800.00	872,559,140.00	269,942,660.00	76.4
Даатгалын үйлчилгээ	2,029,700.00	-	2,029,700.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	344,500.00	344,469.00	31.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	71,700.00	22,000.00	49,700.00	30.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	70,917,200.00	46,484,440.00	24,432,760.00	65.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,801,200.00	716,000.00	2,085,200.00	25.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1,749,134,400.00	1,154,574,884.00	594,559,516.00	66.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,701,994,400.00	1,107,634,884.00	594,359,516.00	65.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	47,140,000.00	46,940,000.00	200,000.00	99.6
ТАТААС	6,554,987,500.00	6,554,987,500.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,208,072,300.00	5,208,072,300.00	-	100.0

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,208,072,300.00	5,208,072,300.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,346,915,200.00	1,346,915,200.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,346,915,200.00	1,346,915,200.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,248,844,900.00	1,755,240,854.00	493,604,046.00	78.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,146,687,400.00	1,683,191,854.00	463,495,546.00	78.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,146,687,400.00	1,683,191,854.00	463,495,546.00	78.4
Бусад урсгал шилжүүлэг	102,157,500.00	72,049,000.00	30,108,500.00	70.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,004,300.00	7,249,000.00	9,755,300.00	42.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,153,200.00	64,800,000.00	20,353,200.00	76.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	89	69	20	77.5
Удирдах ажилтан	23	11	12	47.8
Гүйцэтгэх ажилтан	62	52	10	83.9
Үйлчлэх ажилтан	4	6	(2)	150.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	87	69	18	79.3
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	83	59	24	71.1
Ажлын албаны албан хаагч (АА)	1	3	(2)	300.0
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	-	4	(4)	-
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	9,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,900.00
122	Тусламжийн орлого	-	9,900.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,900.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,900.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		9,900.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь эрхэм зорилгоо “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хиймэл оюун, их өгөгдөл, кибер аюулгүй байдал, инновац болон харилцаа холбоо, дижитал шилжилтийн хөгжлийн үндэсний бодлого, стратеги, дунд ба урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын судалгаа, төлөвлөлтийн аргачлалыг сайжруулж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих. Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулж, удирдамжаар хангах;
- Хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, гадаад хамтын ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа болон яамны хэвийн, үр ашигтай үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах, хууль ёсны хүрээнд хяналттай хэрэгжүүлэх;
- Хүн төвтэй дижитал засаглал болон инновацын бодлого, стратеги, төслүүдийн хэрэгжилтийг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, төрийн үйлчилгээний бүх төрлийг цахимаар авах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн байгууллагуудын дижитал чадавхыг бэхжүүлэх, нээлттэй инновацын эко системийг хөгжүүлэх, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Харилцаа холбооны салбарын бодлого, эрх зүйн орчны хэрэгжилтийг зохион байгуулах, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж, чанар, найдвартай байдлыг хангах, хөгжлийг хурдасгах, сансрын холбооны дэд бүтцийг хөгжүүлэх стратеги боловсруулж батлуулах хэрэгжилтийг хангах, үндэсний кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах, холбогдох хууль, стандарт, зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах;
- Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийг хангуулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийж, сайжруулах зөвлөмж боловсруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх замаар холбогдох хууль, тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай ажиллагааг хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, сайдын эрхлэх асуудал (харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновац, радио давтамж, сансрын технологи, өргөн нэвтрүүлэг, шуудан, дижитал шилжилт, харилцан уялдаа бүхий ухаалаг засаглал, дижитал дэд бүтэц, инновацилаг цахим эдийн засаг, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, төр-хувийн хэвшлийн түншлэл, кибер аюулгүй байдал, тоон гарын үсэг цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, цахим худалдаа, бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого, зохицуулалт, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх)-ын хүрээний бодлогыг тодорхойлох, зохицуулах, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа агентлагийн үйл ажиллагааг шуурхай зохицуулах, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Тус яам нь Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Цахим гарын үсгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Инновацийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тэдгээрт хамаарах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам” 98 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмж батлах тухай” 108 дугаар тогтоол.

Мөн яам нь Засгийн газрын 2007 оны 60, 2009 оны 336, 2020 оны 160 дугаар тогтоолоор Монгол Улсын гадаад хамтын ажиллагааны хүрээнд олон улсын 6 байгууллагад гишүүнчлэлийн татвар, төлбөр хураамжийг төлж байна. Тухайлбал:

1. Олон улсын цахилгаан холбооны байгууллага /International Telecommunication Union/
2. Дэлхийн шуудангийн холбоо /Universal Postal Union/
3. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллага /Asia-Pacific Telecommunity/
4. Ази, Номхон далайн шуудангийн холбоо /Asia-Pacific Postal Union/
5. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага /Asia-Pacific Space Cooperation Organization/
6. Бүс нутгийн харилцаа холбооны хамтын нийгэмлэг /Regional Commonwealth in the field of Communications

Яамны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", мөн сайдын 2024 оны А/38 тушаалаар баталсан “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу яамны санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод аудитыг хийгээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дүгээр тушаалаар баталсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын харьяа төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 415,337.7 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30.2	-	(30.2)
Авлага	31,694.5	15,771.6	(15,922.9)
Урьдчилгаа	236,116.0	312,477.8	76,361.8
Бараа материал	294,443.0	910,485.4	616,042.4
Нөөцийн бараа	189,807.8	20,792.2	(169,015.6)
Үндсэн хөрөнгө	3,462,624.6	2,539,851.4	(922,773.2)
Нийт хөрөнгө	4,214,716.1	3,799,378.4	(415,337.7)
Өр төлбөр	1,308,492.4	1,628,630.8	320,138.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,906,223.7	2,170,747.6	(735,476.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,214,716.1	3,799,378.4	(415,337.7)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Тухайлбал,

Урьдчилгаа дансны 312,477.9 мянган төгрөгийн үлдэгдэлд Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-д зааснаар инновацийн төсөл шалгаруулалтад шалгарсан 14 оролцогчид олгосон 280,000.0 мянган төгрөг, өмнөх оны онгоцны тийзний урьдчилж төлсөн төлбөр болох 32,477.9 мянган төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 910,485.4 мянган төгрөг болж өмнөх оноос 616,042.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 575,000.0 мянган төгрөгийн 13 судалгааны ажлын тайланг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нөөцийн бараа материал 20,792.2 мянган төгрөг болж өмнөх оноос 169,015.6 мянган төгрөгөөр буурсан нь И-Монгол академи УТҮГ-т ЦХИХХС-ын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/138 тоот тушаалаар 189,807.8 мянган төгрөгийн бараа шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд тайлант онд орон нутгийн улсын хяналтын байцаагч нарт 20,792.2 мянган төгрөгийн 13 ширхэг ipad худалдан авч нөөцөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,539,851.4 мянган төгрөг болж өмнөх оноос 922,773.2 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 510 дугаар тогтоолоор 187,181.5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоосон, 520 дугаар тогтоолоор 204,623.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, А-1/2311 тоот албан бичгээр 241,800.0 мянган төгрөгийн хөрөнгө Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсэн, тайлант онд бүртгэсэн 1,467,964.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэргээс голлон шалтгаалжээ. Мөн тайлант онд 100,195.8 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авч, ТӨБЗГ-ын 532 дугаар тогтоолоор Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд байрлах Анхны холбооны барилга, холбогдох газар эзэмших эрхийн 237,288.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Биет бус хөрөнгөд цахим аймаг хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул, Өвөрхангай аймгуудад хэрэгжүүлсэн 2,960,711.3 мянган төгрөгийн системүүд, 1,662,496.9 мянган төгрөгийн программ хангамж, 50,475.7 мянган төгрөгийн лиценз бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,628,630.8 мянган төгрөг болж өмнөх оноос 320,138.4 мянган төгрөгөөр өссөн нь ажил, үйлчилгээг хүлээн авсан актыг үндэслэн байгууллагад төлөх өглөг 311,862.0 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 5,191.5 мянган төгрөгийг бүртгэсэн нь голлон нөлөөлжээ.

Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ 2,154,976.0 мянган төгрөг болж өмнөх оноос 751,247.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 52,042,489.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил үйлчилгээний зардлыг 13,479,908.1 мянган төгрөг, татаасыг 4,861,487.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 294,546.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж 33,406,547.5 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 33,406,547.5 мянган төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвөөс бараа, ажил үйлчилгээний зардлыг 16,614,320.0 мянган төгрөг, татаасыг 15,012.5 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 78,452.8 мянган төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, 16,698,762.2 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,698,762.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гүйцэтгэлээр 15,426,057.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 14,548,972.5 мянган төгрөг зарцуулж, 877,085.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,548,972.5 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 854,035.2 мянган төгрөг, цахим шилжилт арга хэмжээ 530,384.9 мянган төгрөг, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж 463,495.6 мянган төгрөгөөр тус тус арга хэмжээний зардлуудыг дутуу зарцуулснаас голлон шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71302	Мэдээлэл технологийн нэгдсэн дэд бүтэц	16,698,762.2	14,548,972.4	2,149,789.8	87.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,234,205.1	4,380,169.9	854,035.2	83.7
1.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	10,000.0	10,000.0	-	100.0
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	281,372.5	193,061.4	88,311.1	68.6
1.4	80307	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох	17,594.5	15,771.6	1,822.9	89.6
1.5	80316	Цахим шилжилт арга хэмжээ	1,503,993.4	973,608.5	530,384.9	64.7
1.6	80329	Тээврийн үйлчилгээ	-	-	-	-
1.7	80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	2,146,687.4	1,683,191.9	463,495.5	78.4
1.8	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	85,153.2	64,800.0	20,353.2	76.1
1.9	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	17,004.3	7,249.0	9,755.3	42.6
1.10	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	212,499.9	127,600.0	84,899.9	60.0
1.11	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	88,904.5	68,732.6	20,171.9	77.3
1.12	81805	Инновац, өндөр технологи	546,359.9	469,800.0	76,559.9	86.0
1.13	82402	INTELSAT ба REUTERS-ийн суваг ашигласны төлбөр	1,346,915.2	1,346,915.2	-	100.0
1.14	82403	Радио шугам, хиймэл дагуул, VPN ашиглалт	5,208,072.3	5,208,072.3	-	100.0

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны хязгаар тогтоох тухай” 07 дугаар тогтоолын дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/263 тоот тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо 89 болгон 9 хувиар бууруулсан байна.

Бүтцийн шинэчлэлээр 8 газар, 9 хэлтэс, нийт орон тоо 98 байсныг 5 газар, 5 хэлтэс болгон удирдах 7 албан тушаалтан, гүйцэтгэх 2 албан тушаалтаныг цомхотгон 89 орон тоотойгоор батлагдсан, гүйцэтгэлээр тайлант онд 73 орон тоотойгоор ажилласан байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/290 тоот тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 37.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Гадаад албан томилолтын зардалд өмнөх оны урьдчилж төлсөн зардлаас 9,118.8 мянган төгрөг, тайлант оны төсвөөс 29,265.1 мянган төгрөг зарцуулсан байна. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 6 арга хэмжээнд 9 албан хаагч албан томилолтоор ажилласнаас

гадаад хамтын ажиллагааны гишүүнчлэлтэй байгууллагын урилгаар 2, Төрийн айлчлалын бүрэлдэхүүнд ажиллахаар 1, яамны чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой 3 арга хэмжээнд тус тус оролцсон байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 46,940.0 мянган төгрөг, цахим шилжилт арга хэмжээнээс 149,202.0 мянган төгрөг, олон улсын гишүүнчлэлийн байгууллагын хураамжаас 89,880.0 мянган төгрөг, олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээнээс 122,800.0 мянган төгрөг, инновац, өндөр технологийн арга хэмжээнээс 13,500.0 мянган төгрөгийг хурал зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээнд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, санхүүжүүлсэн байна.

Цахимаар түрүүнд /Digital first/ цахимжуулалтын үйл ажиллагааны талаар контент хийлгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлахад 94,890.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 128/ШШ2025/0597, 128/ШШ2025/0621 дугаартай шийдвэрүүдээр буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны ажилгүй байх хугацааны нөхөн олговорт 15,771.6 мянган төгрөг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд “Мэдээлэл технологийн тэргүүний ажилтан” тэмдэгээ гээгдүүлсэн албан хаагчид тэмдэг нөхөн олгосны 9.9 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01, А/237, А/311 тоот тушаалуудаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 190,000.0 мянган төгрөгийн 1, харьцуулалтын аргаар 1,237,000.0 мянган төгрөгийн 19, шууд худалдан авалтын аргаар 549,500.0 мянган төгрөгийн 30, ерөнхий гэрээний аргаар 28,000.0 мянган төгрөгийн худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 1,552,778.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

- Харьцуулалтын аргаар 1,012,543.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, контент, судалгаа, хурал зохион байгуулах ажил;
- Шууд худалдан авалтын аргаар 518,400.0 мянган төгрөгийн сургалт судалгаа, контент, лицензийн эрх авах бараа, ажил үйлчилгээ;
- Ерөнхий гэрээний аргаар 21,835.4 мянган төгрөгийн лиценз.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн яамны үйл ажиллагааг сайжруулах батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг он дамнуулан зарцуулахгүй байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Т.Баасанцэнд, Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/114 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 23,279,763.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 232,797.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 16,246,702.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 30.2 хувиар буурсан нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 16,230,931.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 162,309.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 256,770.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс улсын төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 8 зөрчил илэрсэнд 2 албан шаардлага, 6 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингаас бусад таван саяас дээш орлогын 19,072,342.0 мянган төгрөгийн 86 гүйлгээ, цалингаас бусад таван саяас дээш зарлагын 16,800,207.5 мянган төгрөгийн 145 гүйлгээг иж бүрэн мэдээллэсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангилалыг тогтоогоогүй байгаагаас худалдан авалтыг тодорхойлох боломжгүй өндөр зардал гарах эрсдэлтэй байна.

Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д "Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангилалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоох асуудлыг 2026 онд багтаан шийдвэрлэж ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан оны эхэнд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж төсвийн жилийн дундуур улсын төсвийн зарцуулалтыг хумиж, төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжээгүй байх, тайлант оны гүйцэтгэл хангагдахгүй байх нөхцөл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 48 дугаар зүйлийн 48.2.1-т "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд, хариуцлагатай зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4.4.2.2 Зөвлөмж

1.Хуулийн хэрэгжилттэй холбоотой:

Илрүүлэлт 1: Салбарын хяналт хэрэгжүүлдэг улсын байцаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нэр төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлээгүй нь хөдөлмөр хамгааллын хэрэгслийн төсөвт өртөг, гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т " Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж, мөрдүүлж ажиллах.

Илрүүлэлт 2: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө систем хоорондын уялдаа, эдийн засгийн үр ашигтай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, аюулгүй, найдвартай байдлын шийдлийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвлөмж, дүгнэлт гаргахаар заасан боловч яамны программ дахь бүртгэлд төрийн байгууллагуудын ашигладаг програм хангамжийн бүртгэл хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 29.4-т зааснаас бусад нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулна", 29.1.1-т "нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд бүртгэлтэй болон бүртгэлгүй программын жагсаалтыг ашиглалтын хамт авч нэгтгэн сан бүрдүүлэх асуудлыг 2026 оны 2 дугаар улиралд багтаан тэдгээрийн оролцоог хангах замаар хамтран хэрэгжүүлэх асуудлыг дээд шатны төсөв захирагчид хандан шийдвэрлүүлэн ажиллах, төсвийн ерөнхийлөн захирагчдын 2027 оны төсвийн төслийн саналд тусгагдахаар төлөвлөгдөж байгаа нийтийн мэдээллийн систем үүсгэх саналыг ЦХИХХЯ-аас дүгнэлт зөвлөмжийг үндэслэн боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлдэг байх асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх.

Илрүүлэлт 3: Монгол Улсын засгийн газрын тухай хуульд Эдийн засаг, хөгжлийн сайдад шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хамааруулсан боловч Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдад үндэсний инновацийн тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудлыг хамааруулсан нь харилцаа холбоо, мэдээллийн технологи хариуцсан чиглэлийн яамны чиг үүрэгтэй нийцэхгүй, салбарын бодлого хоорондын уялдаа хангагдахгүй байх, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжилтнүүд байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй, үр ашиггүй зардлууд гарах эрсдэлтэй байна.

Энэ нь Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.1-д "үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах", Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 3-т Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана: Ерөнхий чиг үүргийн: 1/Эдийн засаг, хөгжлийн яам, Чиглэлийн:14/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам", 20 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүн 1/Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд: -шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого,

төлөвлөлт; -эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого; -аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; -оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал; 20/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд:-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцооны бодлого, төлөвлөлт, хөгжүүлэх асуудал" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өндөр технологи, үндэсний инновацийн асуудал нь шинжлэх ухаан, технологийн болон аж үйлдвэрийн нэгдсэн бодлоготой холбоотой тул салбарын уялдааг хангах үүднээс яамны чиг үүргээс үндэсний инновацийн асуудлыг салган Эдийн засаг, хөгжлийн яаманд хариуцуулах асуудлыг дээд шатны төсөв захирагчид уламжилж, шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 4: Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, сул орон тоог нөхөх зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс яамны үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, хүний нөөцийн чадавхи сулрах эрсдэлтэй байна.

Энэ нь Монгол Улсын засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолын 15 дугаар хавсралт "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сул орон тоог нөхөн, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 5: Тайлант онд аж ахуйн нэгжүүдээр гэрээний дагуу гүйцэтгүүлсэн 459,380.0 мянган төгрөгийн 9 судалгааны ажлын тайланг ил тод мэдээллээгүй байна.

Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана: 8.4.27-д "мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлсэн судалгаа, шинжилгээний ажлуудын тайланг ил тод нээлттэй мэдээлж байх.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт 6: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон төсвийн тухай хуулийн 1-р хавсралтад тусгагдсан хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь хоорондоо уялдахгүй байгаа нь шаардлагагүй төсвийн зарцуулалт гаргах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйл "Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага: 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх", Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг", 6 дугаар зүйлийн 6.10.3-д "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон Төсвийн тухай хуулийн хавсралт 1-т тусгагдсан хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг уялдуулан төлөвлөж байх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө болон зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 239,650.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил бүхий асуудлын бүртгэлийг боловсруулж, 2 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 8 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тус яаманд хүргүүлсэн 569,438.8 мянган төгрөгийн 4 албан шаардлагын биелэлт 75.0 хувьтай, 188,785.0 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай, нийт шийдвэрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	569,438.8	3	411,662.0	75.0
Зөвлөмж	6	188,785.0	6	188,785.0	100.0
Нийт дүн	10	758,223.8	9	600,447.0	90.0

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, төсөвт батлагдаагүй зардал санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсөв, санхүүгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант оны богино хугацаат өр төлбөрийн 1,628,630.8 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн;
- Байгууллагын ашигладаг санхүүгийн программ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүрэн шинэчлэл хийгдсэн эсэх;
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар", "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэх;
- "Цахим аюулгүй байдлын мэдээлэл, удирдлагын төв" ТББ-тай байгуулсан гэрээт ажлын худалдан авах ажиллагааны шалгаруулалт, гүйцэтгэлийг үзэх;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,249.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд балансаас балансад шилжүүлсэн бусад биет бус хөрөнгөнд 2 сарын 3,483.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, сөрөг утгатай бүртгэгдсэн;
- "Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" техник, эдийн засгийн үндэслэл гүйцэтгүүлэх 44,766.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг бусад биет бус хөрөнгөнд бүртгэлгүй бусад хангамжийн материалд бүртгэсэн.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг", Санхүүгийн тайлагналын толилуулга, үнэлгээ ба хуваарилалт мэдэгдлүүдийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-т заасны дагуу залруулгуудыг хийсэн болно.

Аудитаар нийт 1,036,447.3 мянган төгрөгийн 13 зөрчил² илэрснээс, 53,270.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 118,500.0 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, 844,677.2 мянган төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 20,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,036,447.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 874,138.0 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Эйрлинк монголиа ХХК-д 2024 онд шилжүүлэн, урьдчилгаа дансанд бүртгэсэн, тайлант оны санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнасан 32,477.9 мянган төгрөгийн онгоцны тийзний урьдчилж төлсөн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлээгүй 32,477.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоолоо.

Илрүүлэлт 2: Орон нутгийн төсвөөс цалинждаг, яамны бүтцэд хамааралгүй салбарын хяналтын улсын байцаагчийн эрхтэй 13 албан хаагчид тоног төхөөрөмж шилжүүлэхээр 20,792.2 мянган төгрөгийн 13 ширхэг /*ipad*/ худалдан авч нөөцөлсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим"-д 4.1.3-т "үр ашигтай байх, 4.1.9-д "хариуцлагатай байх", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Яамны чиг үүрэгт хамааралгүй асуудлаар орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдад шилжүүлэхээр худалдан авч нөөцөлсөн 13 ширхэг тоног төхөөрөмжийн 20,792.2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант оны төсвийн төсөлд тусгаж батлуулаагүйгээр арга хэмжээ, судалгааны ажлын зардалд 118,500.0 мянган төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Инновацийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2015 онд хасагдсан "Инновацийн сан"-ийн эрх зүйн зохицуулалттай холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний судалгааг хийгээгүйгээр "Инновацийг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулах судалгаа"-ны ажилд 98,000.0 мянган төгрөг зарцуулсан. Тус судалгааны үр дүнг 2025 онд ашиглаагүй, 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь судалгааны ажлын үр нөлөө буурах, тоон мэдээллийн ач холбогдол алдагдах эрсдэлтэй;
- Сургалтын үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуй нэгжээр нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулахад Дижитал сервис ХХК-д 10,500.0 мянган төгрөг шилжүүлсэн;
- Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулахад Номадрент ХХК-д 10,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн "Төсвийг дор дурдсаны дагуу ангилна. 22.2.3.эдийн засгийн ангиллаар; ; 22.2.4.хөтөлбөрөөр; 22.2.5 арга хэмжээгээр; 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.үр ашигтай байх; , 4.1.6.сахилга баттай байх; , 4.1.9.хариуцлагатай байх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлөвлөж, батлуулаагүй арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Азийн хөгжлийн банкт байгуулсан "Техникийн туслалцааны хөтөлбөр" төслийн хүрээнд цахим шилжилт, цахим засаглалыг эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдалд хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлэх зорилгоор 248,717.3 мянган төгрөгийн 130 ширхэг нөүтбүүк, 50 ширхэг рөүтэр үнэ төлбөргүй шилжүүлснийг санхүүгийн тайланд бүртгэн ЦХИХХС-ын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/85 тоот тушаалаар 7 аймгийн Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн ч тулган баталгаажуулалтаар тухайн хөрөнгүүдийг хүлээн авагч байгууллагууд хүлээж аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, биетээр оршин байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.", 25 дугаар зүйлийн 25.4-т "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:", 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно:", 25.5.2-т "байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим "5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх;", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн хүрээнд хүлээн авсан 248,717.3 мянган төгрөгийн хөрөнгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/85 тоот тушаалаар 7 аймгийн Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн боловч тухайн байгууллагуудад хүлээлгэн өгөөгүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 3: Цалин хөлстэй холбоотой нийт 41,531.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хариуцсан шинжээч болон ахлах нягтлан бодогч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр нийт 3,730.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан тушаалаар олгосон;
- Амралтын өдөр, нийтээр тэмдэглэх баярын өдөр болон ажлын өдрүүдэд илүү цагаар ажилласан нь ажлын цагийн бүртгэлд бүртгэгдээгүй албан хаагчдад тушаал гарган ажлын тайлан нотлох баримтгүйгээр 32,921.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хариуцсан ахлах шинжээч, аудиторыг хавсран гүйцэтгүүлэхээр томилж, ажил хавсран гүйцэтгэсний 40 хувийн нэмэгдэлд 4,880.0 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"; Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно.", 84 дүгээр зүйлийн 84.5.-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.", Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно., Засгийн газрын 2015 оны "Дотоод аудитын дүрэм" батлах 483 дугаар тогтоолын хавсралт 4.10."Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагчаар санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгүүлсэн, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй албан хаагчдад урамшуулал давхардуулан олгосон, илүү цагаар ажилласан тайлан, цагийн бүртгэлгүйгээр илүү цагийн хөлс олгодог зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 4: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бүтцэд батлагдсан мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудын орон тоонд боловсрол, мэргэшлийн шаардлага хангаагүй 2 албан хаагчийг /санхүү, эдийн засгийн болон сэтгүүлч мэргэжилтэй/ томилж 110,236.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.15-т "Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай хүнийг тухайн чиглэлээр төрийн албанд ажиллуулах шаардлагатай бол албан тушаалын цалингийн итгэлцүүр, шатлалыг Засгийн газар тогтооно.", Монгол Улсын засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоолын 1, 2-р хавсралт гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтны албан тушаалын ажлын байранд шаардлага хангахгүй албан хаагчдыг томилж, цалин хөлсийг олгосон зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 5: Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын Цахим эдийн засаг, салбар дундын уялдаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, төрийн захиргааны удирдлагын газрын Архив,

бичиг хэргийн мэргэжилтэн болох 2 албан хаагчийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговрын 15,771.6 мянган төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон зөрчлийг таслан зогсоож, олгосон нөхөн олговрыг авлагаар бүртгэж, байгууллагыг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 6: Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 298,419.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд:

1. Харилцагч байгууллагын гэрээний гүйцэтгэл, талуудын эрх, үүрэг хариуцлагатай холбоотой нийт 135,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.
 - Гэрээний тусгай нөхцөлд гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагын заалт тусгаагүйгээс гэрээний үүргийг хангаагүй 1 аж ахуйн нэгжийн 38,000.0 мянган төгрөгийн үйлчилгээний төлбөрөөс хугацаа хоцроосон алданги тооцож суутгах боломжгүй болсон, хууль зөрчиж хугацааг сунгасан;
 - Гэрээний гүйцэтгэл хангаагүй 2 аж ахуйн нэгжийн нийт 97,000.0 мянган төгрөгийн гэрээний хугацааг хууль зөрчиж ЦХИХХЯ-ы төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/234 тоот тушаалаар сунгасан, гэрээний тусгай нөхцлийн 10.22-д заасны дагуу гүйцэтгэгчийн төлөх алдангийн дүнг тооцож үнийн дүнгээс суутгаагүй байна.
2. Төсвийн төсөлд тусгаагүй, Худалдан авах ажиллагааны анхны төлөвлөгөөнд батлаагдаагүй ажлуудыг нэмэлтээр төлөвлөж, 138,766.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн:
 - Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан платформд хөгжүүлэлт хийлгэх зардалд 94,000.0 мянган төгрөгийн гэрээг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулж, ажлыг хүлээж авсан;
 - Урсгал төсвөөс "Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" техник, эдийн засгийн үндэслэл гүйцэтгүүлэх ажилд 44,766.0 мянган төгрөг зарцуулахаар гэрээ байгуулж, акт үйлдсэн;
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/311 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан "мэдээллийн технологийн мэргэжилтний бүртгэлийн систем" хөгжүүлэхээр 19,965.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн акт үйлдсэн;
4. Ажилтнуудтай холбоотой нэг удаагийн тусламж, дэмжлэг, хувь хүмүүст төлөх өглөг 4,688.8 мянган төгрөг;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно: 40.1.1-т "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах", 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 7: Монгол шуудан ХК-ийн 2025 оны эдийн засгийн зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2025 оны 06 дугаар сарын 30-аас 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Ази номхон далайн бүс нутгийн шуудангийн холбооны хурал"-ын зохион байгуулалтын ажлын санхүүжилтэд 50,000.0 мянган төгрөгийг 2025 оны 09 дүгээр сард батлагдсан төсвөөс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 5.1.5-д "хариуцлагатай байх.", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн чиг үүрэгт хамаарахгүй, 100.0 хувь өөрийн орлогоор санхүүждэг байгууллагад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 8: Тайлант онд судалгаа, тайлан боловсруулах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаас зайлсхийж, ажлын төсөвт өртгийг тооцоо судалгаанд үндэслээгүй харилцан адилгүй төлөвлөж, шууд болон харьцуулалтын аргаар гүйцэтгүүлэхээр тусган төлөвлөж, гүйцэтгэлээр 556,180.0 мянган төгрөгийн 12 гэрээ байгуулсан. Бодлого тодорхойлох аливаа арга хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг эрэмбэлж, хүрэх үр дүнтэй уялдуулан төсөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх;" 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;" Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бодлого тодорхойлох аливаа арга хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг эрэмбэлж, хүрэх үр дүнтэй уялдуулан төсөвлөж, зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ.

Илрүүлэлт 9: "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" судалгааны ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод програм хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байж болно гэж тусган судалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй, ажлын туршлагад судалгаа шинжилгээний ажил хийж байгаагүй байгууллагыг сонгон шалгаруулж, 80,000.0

мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гүйцэтгэгчээс хүлээн авсан судалгааны ажлын тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ашиглаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т "бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний туршлагатай байх шаардлага хангасан байгууллагыг сонгон шалгаруулж байх, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн заалттай холбоотой

Илрүүлэлт 1: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах чиг үүргийг төлбөртэй хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай. Тайлант онд тус үйл ажиллагаатай холбоотой 15,000.0 мянган төгрөгийн орлогыг өөрийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно: 47.1.1-т "төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж;"..... 47.1.8-т "гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын олсон нэмэлт орлого.", Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар бүлэг: 8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: 9.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: 9.1.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30 дугаар зүйл. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ: 30.1-т "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, сунгахад доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:" 30.1.1-т тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 5 000 000 төгрөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогыг өөрийн нэмэлт дансаар дамжуулахгүй байх.

Илрүүлэлт 2: Салбарын хяналтын улсын байцаагчийн эрхтэй 5 албан хаагчид хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авахаар төлөвлөсөн ч нийт 5,000.0 мянган төгрөг буюу 2 иж бүрэн хувцас илүү авсан байна. /Үүнээс: хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэхгүй албан хаагчид 1 иж бүрдэл, батлагдсан орон тоонд томилогдох 2 албан хаагчийн хүйс, биеийн хэмжээг тооцоолоогүй 2 иж бүрдэл/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим"-ын 4.1.3-т "үр ашигтай байх, 4.1.9-д "хариуцлагатай байх", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт тусгаж, тооцоолон, төлөвлөсөн арга хэмжээний дагуу худалдан авалтыг зохион байгуулж, санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд балансаас балансад шилжүүлсэн бусад биет бус хөрөнгөнд 2 сарын элэгдэл тооцож, сөрөг утгатай бүртгэгдсэн байна.	1	3,483.3	-	-	1	3,483.3	1	3,483.3	-	-	-	-
"Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" техник, эдийн засгийн үндэслэл гүйцэтгүүлэх 44,766.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг бусад биет бус хөрөнгөнд бүртгэлгүй бусад хангамжийн материалд бүртгэсэн байна.	1	44,766.0	-	-	1	44,766.0	1	44,766.0	-	-	-	-
Дүн	2	48,249.3	-	-	2	48,249.3	2	48,249.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Азийн хөгжлийн банктай байгуулсан "Техникийн туслалцааны хөтөлбөр" төслийн хүрээнд цахим шилжилт, цахим засаглалыг эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдалд хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлэх зорилгоор 248,717.3 мянган төгрөгийн 130 ширхэг нөүтбүүк, 50 ширхэг рөүтэр үнэ төлбөргүй шилжүүлснийг санхүүгийн тайланд бүртгэн ЦХИХХС-ын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/85 тоот тушаалаар 7 аймгийн Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн ч тулган баталгаажуулалтаар тухайн хөрөнгүүдийг шилжүүлсэн байгууллагууд хүлээж аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, биетээр оршин байхгүй байна.	1	248,717.3	-	-	1	248,717.3	-	-	-	-	1	248,717.3
Цалин хөлстэй холбоотой нийт 41,531.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: - Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хариуцсан шинжээч болон ахлах нягтлан бодогч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр нийт 3,730.0 мянган төгрөгийн урамшууллыг	1	41,531.8	-	-	1	41,531.8	-	-	-	-	-	-

улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан тушаалаар олгосон, - Амралтын өдөр, нийтээр тэмдэглэх баярын өдөр болон ажлын өдрүүдэд илүү цагаар ажилласан нь ажлын цагийн бүртгэлд бүртгэгдээгүй албан хаагчдад тушаал гарган ажлын тайлан нотлох баримтгүйгээр 32,921.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, - ЦХИХХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хариуцсан ахлах шинжээч, аудиторыг хавсран гүйцэтгүүлэхээр томилж, ажил хавсран гүйцэтгэсний 40 хувийн нэмэгдэлд 4,880.0 мянган төгрөгийг олгосон.												
ЦХИХХЯ-ны бүтцэд батлагдсан мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудын оронд тоонд боловсрол, мэргэшлийн шаардлага хангаагүй 2 албан хаагчийг /санхүү, эдийн засгийн болон сэтгүүлч мэргэжилтэй/ томилж 110,236.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.	1	110,236.7	-	-	1	110,236.7	-	-	-	-	-	-
Эйрлинк монголиа ХХК-д 2024 онд шилжүүлэн, урьдчилгаа дансанд бүртгэсэн, тайлант оны санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнасан 32,477.9 мянган төгрөгийн онгоцны тийзний урьдчилж төлсөн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	32,477.9	1	32,477.9	-	-	-	-	-	-	-	-
Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн цалин хөлс, нийгмийн даатгалын	1	15,771.6	-	-	1	15,771.6	-	-	-	-	-	-

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

шимтгэлийн нөхөн олговрын 15,771.6 мянган төгрөгийг байгууллагаас олгосон байна.												
Орон нутгийн төсвөөс цалинждаг, яамны бүтцэд хамааралгүй салбарын хяналтын улсын байцаагчийн эрхтэй 13 албан хаагчид тоног төхөөрөмж шилжүүлэхээр 20,792.2 мянган төгрөгийн 13 ширхэг /рад/ худалдан авч нөөцөлсөн.	1	20,792.2	1	20,792.2	-	-	-	-	-	-	-	-
Салбарын хяналтын улсын байцаагчийн эрхтэй 5 албан хаагчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авахаар төлөвлөсөн ч нийт 5,000.0 мянган төгрөг буюу 2 иж бүрэн хувцас илүү авсан /Үүнээс: хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэхгүй албан хаагчид 1 иж бүрдэл, батлагдсан орон тоонд томилогдох 2 албан хаагчийн хүйс, биеийн хэмжээг тооцоолоогүй 2 иж бүрдэл/.	1	5,000.0	-	-	-	-	1	5,000.0	-	-	-	-
Тайлант оны төсвийн төсөлд тусгаж батлуулаагүйгээр арга хэмжээ, судалгааны ажлын зардалд 118,500.0 мянган төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд: - Инновацийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2015 онд хасагдсан "Инновацийн сан"-ийн эрх зүйн зохицуулалттай холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний судалгааг хийгээгүйгээр "Инновацийг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулах судалгаа"-ны ажилд 98,000.0 мянган төгрөг зарцуулсан. Тус судалгааны үр дүнг 2025 онд ашиглаагүй, 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь судалгааны ажлын үр нөлөө буурах, тоон мэдээллийн ач холбогдол алдагдах эрсдэлтэй;	1	118,500.0	-	-	-	-	-	-	1	118,500.0	-	-

<p>- Сургалтын үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуй нэгжээр нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулахад Дижитал сервис ХХК-д 10,500.0 мянган төгрөг шилжүүлсэн;</p> <p>- Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулахад Номадрент ХХК-д 10,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.</p>											
<p>Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 298,419.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд:</p> <p>1. Харилцагч байгууллагын гэрээний гүйцэтгэл, талуудын эрх, үүрэг хариуцлагатай холбоотой нийт 135,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.</p> <p>- Гэрээний тусгай нөхцөлд гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагын заалт тусгаагүйгээс гэрээний үүргийг хангаагүй 1 аж ахуйн нэгжийн 38,000.0 мянган төгрөгийн үйлчилгээний төлбөрөөс хугацаа хоцроосон алданги тооцож суутгах боломжгүй болсон, хууль зөрчиж хугацааг сунгасан;</p> <p>- Гэрээний гүйцэтгэл хангаагүй 2 аж ахуйн нэгжийн нийт 97,000.0 мянган төгрөгийн гэрээний хугацааг хууль зөрчиж ЦХИХХЯ-ы төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/234 тоот тушаалаар сунгасан, гэрээний тусгай нөхцлийн 10.22-д заасны дагуу</p>	1	298,419.8	-	-	1	298,419.8	-	-	-	-	-

<p>гүйцэтгэгчийн төлөх алдангийн дүнг тооцож үнийн дүнгээс суутгаагүй байна.</p> <p>2. Төсвийн төсөлд тусгаагүй, Худалдан авах ажиллагааны анхны төлөвлөгөөнд батлаагдаагүй ажлуудыг нэмэлтээр төлөвлөж, 138,766.0 мянган төгрөг:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан платформд хөгжүүлэлт хийлгэх зардалд 94,000.0 мянган төгрөгийн гэрээг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулж, ажлыг хүлээж авсан; - Урсгал төсвөөс "Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" техник, эдийн засгийн үндэслэл гүйцэтгүүлэх ажилд 44,766.0 мянган төгрөг зарцуулахаар гэрээ байгуулж, акт үйлдсэн; <p>3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/311 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан "мэдээллийн технологийн мэргэжилтний бүртгэлийн систем" хөгжүүлэхээр 19,965.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн акт үйлдсэн;</p> <p>4. Ажилтнуудтай холбоотой нэг удаагийн тусламж, дэмжлэг, хувь хүмүүст төлөх өглөг 4,688.8 мянган төгрөг;</p>												
<p>Монгол шуудан ХК-ийн 2025 оны эдийн засгийн зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2025 оны 06 дугаар сарын 30-аас 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Ази номхон далайн бүс нутгийн шуудангийн холбооны хурал"-ын зохион байгуулалтын ажлын санхүүжилтэд 50,000.0 мянган төгрөгийг 2025 оны 09 дүгээр сард батлагдсан төсвөөс олгосон байна.</p>	1	50,000.0	-	-	1	50,000.0	-	-	-	-	-	-

Тайлант онд судалгаа, тайлан боловсруулах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаас зайлсхийж, ажлын төсөвт өртгийг тооцоо судалгаанд үндэслээгүй харилцан адилгүй төлөвлөж, шууд болон харьцуулалтын аргаар гүйцэтгүүлэхээр тусган төлөвлөж, гүйцэтгэлээр 556,180.0 мянган төгрөгийн 12 гэрээ байгуулсан. Бодлого тодорхойлох аливаа арга хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг эрэмбэлж, хүрэх үр дүнтэй уялдуулан төсөвлөөгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
"Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" судалгааны ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийн сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод програм хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байж болно гэж тусган судалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй, ажлын туршлагад судалгаа шинжилгээний ажил хийж байгаагүй байгууллагыг сонгон шалгаруулж, 80,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гүйцэтгэгчээс хүлээн авсан судалгааны ажлын тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ашиглаагүй байна.	1	80,000.0	-	-	1	80,000.0	-	-	-	-	-	-
ЦХИХХЯ нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1	15,000.0	-	-	-	-	1	15,000.0	-	-	-	-

олгох, хугацааг сунгах чиг үүргийг төлбөртэй хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай. Тайлант онд тус үйл ажиллагаатай холбоотой 15,000.0 мянган төгрөгийн орлогыг өөрийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.												
Дүн	13	1,036,447.3	2	53,270.1	8	844,677.2	2	20,000.0	1	118,500.0	1	248,717.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Салбарын хяналт хэрэгжүүлдэг улсын байцаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нэр төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлээгүй нь хөдөлмөр хамгааллын хэрэгслийн төсөвт өртөг, гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна.	1	-	-	-	1	-
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө систем хоорондын уялдаа, эдийн засгийн үр ашигтай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, аюулгүй, найдвартай байдлын шийдлийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвлөмж, дүгнэлт гаргахаар заасан боловч яамны программ дахь бүртгэлд төрийн байгууллагуудын ашигладаг програм хангамжийн бүртгэл хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангилалыг тогтоогоогүй байгаагаас худалдан авалтыг тодорхойлох боломжгүй өндөр зардал гарах эрсдэлтэй байна.	1	-	1	-	-	-
Монгол Улсын засгийн газрын тухай хуульд Эдийн засаг, хөгжлийн сайдад шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хамааруулсан боловч Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдад үндэсний инновацийн тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудлыг хамааруулсан нь харилцаа холбоо, мэдээллийн технологи хариуцсан чиглэлийн яамны чиг үүрэгтэй нийцэхгүй, салбарын бодлого хоорондын уялдаа хангагдахгүй байх, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх	1	-	-	-	1	-

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бодлогыг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжилтнүүд байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй, үр ашиггүй зардлууд гарах эрсдэлтэй байна.						
Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, сул орон тоог нөхөх зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс яамны үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, хүний нөөцийн чадавхи сулрах эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон төсвийн тухай хуулийн 1-р хавсралтад тусгагдсан хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь хоорондоо уялдахгүй байгаа нь шаардлагагүй төсвийн зарцуулалт гаргах эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан оны эхэнд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж төсвийн жилийн дундуур улсын төсвийн зарцуулалтыг хумиж, төсөв татагдахад төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжээгүй байх, тайлант оны гүйцэтгэл хангагдахгүй байх нөхцөл үүссэн байна.	1	-	1	-	-	-
Тайлант онд аж ахуйн нэгжүүдээр гэрээний дагуу гүйцэтгүүлсэн 459,380.0 мянган төгрөгийн 9 судалгааны ажлын тайланг ил тод мэдээллээгүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	8	-	2	-	6	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 15/А014/238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-ТчЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эйрлинк монголиа ХХК-д 2024 онд шилжүүлэн, урьдчилгаа дансанд бүртгэсэн, тайлант оны санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнасан 32,477,900.00 /Гучин хоёр сая дөрвөн зуун далан долоон мянга есөн зуун/ төгрөгийн онгоцны тийзний урьдчилж төлсөн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсөвт төвлөрүүлээгүй 32,477,900.00 /Гучин хоёр сая дөрвөн зуун далан долоон мянга есөн зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), Ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Akr\2026\0225 SAG-9.Docx

1526200048



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 16/АОТ/238
САГ-2026/304/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвөөс цалинждаг, яамны бүтцэд хамааралгүй салбарын хяналтын улсын байцаагчийн эрхтэй 13 албан хаагчид тоног төхөөрөмж шилжүүлэхээр 20,792,200.00 /Хорин сая долоон зуун ерэн хоёр мянга хоёр зуун/ төгрөгийн 13 ширхэг /ipad/ худалдан авч нөөцөлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.9-т "хариуцлагатай байх", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Яамны чиг үүрэгт хамааралгүй асуудлаар орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдад шилжүүлэхээр худалдан авч нөөцөлсөн 13 ширхэг тоног төхөөрөмжийн 20,792,200.00 /Хорин сая долоон зуун ерэн хоёр мянга хоёр зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), Ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 108/АОФТ1238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СГА-ТМЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны төсвийн төсөлд тусгаж батлуулаагүйгээр арга хэмжээ, судалгааны ажлын зардалд 118,500,000.00 /Нэг зуун арван найман сая таван зуун мянган/ төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Инновацийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2015 онд хасагдсан "Инновацийн сан"-ийн эрх зүйн зохицуулалттай холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний судалгааг хийгээгүйгээр "Инновацийг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулах судалгаа"-ны ажилд 98,000,000.00 /Ерэн найман сая/ төгрөг зарцуулсан. Тус судалгааны үр дүнг 2025 онд ашиглаагүй, 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь судалгааны ажлын үр нөлөө буурах, тоон мэдээллийн ач холбогдол алдагдах эрсдэлтэй;
- Сургалтын үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуй нэгжээр нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулахад Дижитал сервис ХХК-д 10,500,000.00 /Арван сая таван зуун мянган/ төгрөг шилжүүлсэн;
- Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулахад Номадрент ХХК-д 10,000,000.00 /Арван сая/ төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн "Төсвийг дор дурдсаны дагуу ангилна. 22.2.5 арга хэмжээгээр; 22.2.4.хөтөлбөрөөр; 22.2.3.эдийн засгийн ангиллаар; 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.үр ашигтай байх, 4.1.6.сахилга баттай байх, 4.1.9.хариуцлагатай байх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт төлөвлөж, батлуулаагүй арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй ахлах нягтлан бодогч О.Золзаяад сахилгын хариуцлага ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 109/АДН1238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Азийн хөгжлийн банктай байгуулсан "Техникийн туслалцааны хөтөлбөр" төслийн хүрээнд цахим шилжилт, цахим засаглалыг эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдалд хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлэх зорилгоор 248,717,275.00 /Хоёр зуун дөчин найман сая долоон зуун арван долоон мянга хоёр зуун далан таван/ төгрөгийн 130 ширхэг нөүтбүүк, 50 ширхэг рөүтэр үнэ төлбөргүй шилжүүлснийг санхүүгийн тайланд бүртгэн Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/85 тоот тушаалаар 7 аймгийн Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн ч тулган баталгаажуулалтаар тухайн хөрөнгүүдийг хүлээн авагч байгууллагууд хүлээж аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, биетээр оршин байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.4-т "үнэн зөв байх;", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн хүрээнд хүлээн авсан 248,717,275.00 /Хоёр зуун дөчин найман сая долоон зуун арван долоон мянга хоёр зуун далан таван/ төгрөгийн хөрөнгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/85 тоот тушаалаар 7 аймгийн Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн боловч тухайн байгууллагуудад хүлээлгэн өгөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 110/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалин хөлстэй холбоотой нийт 41,531,807.49 /Дөчин нэгэн сая таван зуун гучин нэгэн мянга найман зуун долоон төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хариуцсан шинжээч болон ахлах нягтлан бодогч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр нийт 3,730,000.00 /Гурван сая долоон зуун гучин мянган/ төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан тушаалаар олгосон;
- Амралтын өдөр, нийтээр тэмдэглэх баярын өдөр болон ажлын өдрүүдэд илүү цагаар ажилласан нь ажлын цагийн бүртгэлд бүртгэгдээгүй албан хаагчдад тушаал гарган ажлын тайлан нотлох баримтгүйгээр 32,921,807.49 /Гучин хоёр сая есөн зуун хорин нэгэн мянга найман зуун долоон төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/96 дугаар тушаалаар Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хариуцсан ахлах шинжээч, аудиторыг хавсран гүйцэтгүүлэхээр томилж, ажил хавсран гүйцэтгэсний 40 хувийн нэмэгдэлд 4,880,000.00 /Дөрвөн сая найман зуун наян мянган/ төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-14.Docx

1526180300

ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно.", 84 дүгээр зүйлийн 84.5.-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.", Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.", Засгийн газрын 2015 оны "Дотоод аудитын дүрэм" батлах 483 дугаар тогтоолын хавсралтын 4.10-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагчаар санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгүүлсэн, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй албан хаагчдад урамшуулал давхардуулан олгосон, илүү цагаар ажилласан тайлан, цагийн бүртгэлгүйгээр илүү цагийн хөлс олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 111/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны бүтцэд батлагдсан мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудын оронд тоонд боловсрол, мэргэшлийн шаардлага хангаагүй хавсралтад дурдсан 2 албан хаагчийг /санхүү, эдийн засгийн болон сэтгүүлч мэргэжилтэй/ томилж 110,236,672.66 /Нэг зуун арван сая хоёр зуун гучин зургаан мянга зургаан зуун далан хоёр төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.15-т "Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай хүнийг тухайн чиглэлээр төрийн албанд ажиллуулах шаардлагатай бол албан тушаалын цалингийн итгэлцүүр, шатлалыг Засгийн газар тогтооно.", Монгол Улсын засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоолын 1,2-р хавсралт гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтны албан тушаалын ажлын байранд шаардлага хангахгүй албан хаагчдыг томилж, цалин хөлсийг олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.Наранчимэг
П.Чанцалдулам
Ж.Нямцэцэг
Т.Баасанцэнд
Б.Тэгшсүрэн

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 112/АДИТ/238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-Т023

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын Цахим эдийн засаг, салбар дундын уялдаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, төрийн захиргааны удирдлагын газрын Архив, бичиг хэргийн мэргэжилтэн болох 2 албан хаагчийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговрын 15,771,631.00 /Арван таван сая долоон зуун далан нэгэн мянга зургаан зуун гучин нэгэн/ төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон зөрчлийг таслан зогсоож, олгосон нөхөн олговрыг авлагаар бүртгэж, байгууллагыг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 113/АД171238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 298,419,838.00 /Хоёр зуун ерэн найман сая дөрвөн зуун арван есөн мянга найман зуун гучин найман/ төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд:

1. Харилцагч байгууллагын гэрээний гүйцэтгэл, талуудын эрх, үүрэг хариуцлагатай холбоотой нийт 135,000,000.00 /Нэг зуун гучин таван сая/ төгрөгийн зөрчил илэрсэн.
 - Гэрээний тусгай нөхцөлд гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагын заалт тусгаагүйгээс гэрээний үүргийг хангаагүй 1 аж ахуйн нэгжийн 38,000,000.00 /Гучин найман сая/ төгрөгийн үйлчилгээний төлбөрөөс хугацаа хоцроосон алданги тооцож суутгах боломжгүй болсон, хууль зөрчиж хугацааг сунгасан;
 - Гэрээний гүйцэтгэл хангаагүй 2 аж ахуйн нэгжийн нийт 97,000,000.00 /Ерэн долоон сая/ төгрөгийн гэрээний хугацааг хууль зөрчиж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/234 тоот тушаалаар сунгасан, гэрээний тусгай нөхцлийн 10.22-д заасны дагуу гүйцэтгэгчийн төлөх алдангийн дүнг тооцож үнийн дүнгээс суутгаагүй байна.
2. Төсвийн төсөлд тусгаагүй, Худалдан авах ажиллагааны анхны төлөвлөгөөнд батлаагдаагүй ажлуудыг нэмэлтээр төлөвлөж, 138,766,000.00 /Нэг зуун гучин найман сая долоон зуун жаран зургаан мянган/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн:
 - Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан платформд хөгжүүлэлт хийлгэх зардалд 94,000,000.00 /Ерэн дөрвөн сая/ төгрөгийн гэрээг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулж, ажлыг хүлээж авсан;
 - Урсгал төсвөөс "Харилцаа холбооны хээрийн дэд бүтцийн нэг маягийн зураг төсөл, төсөв боловсруулах" техник, эдийн засгийн үндэслэл гүйцэтгүүлэх ажилд 44,766,000.00 /Дөчин дөрвөн сая долоон зуун жаран зургаан мянган/ төгрөг зарцуулахаар гэрээ байгуулж, акт үйлдсэн;
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/311 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан "мэдээллийн технологийн мэргэжилтний бүртгэлийн систем" хөгжүүлэхээр 19,965,000.00 /Арван есөн сая есөн зуун жаран таван мянган/ төгрөгийн шууд гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн акт үйлдсэн.


4. Ажилтнуудтай холбоотой нэг удаагийн тусламж, дэмжлэг, хувь хүмүүст төлөх өглөг 4,688,838 /Дөрвөн сая зургаан зуун наян найман мянга найман зуун гучин найман/ төгрөг;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:", 40.1.1-т "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах", 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН		Ц.НАРАНЧИМЭГ
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		П.ЧАНЦАЛДУЛАМ
АУДИТЫН МЕНЕЖЕР		Ж.НЯМЦЭЦЭГ
АХЛАХ АУДИТОР		Т.БААСАНЦЭНД
АУДИТОР		Б.ТЭГШСҮРЭН

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 114/АД171238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол шуудан ХК-ийн 2025 оны эдийн засгийн зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2025 оны 06 дугаар сарын 30-аас 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Ази номхон далайн бүс нутгийн шуудангийн холбооны хурал"-ын зохион байгуулалтын ажлын санхүүжилтэд 50,000,000.00 /Тавин сая/ төгрөгийг 2025 оны 09 дүгээр сард батлагдсан төсвөөс олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 5.1.5-д "хариуцлагатай байх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн чиг үүрэгт хамаарахгүй, 100.0 хувь өөрийн орлогоор санхүүждэг байгууллагад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 115/АОН1238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СГА-ТчЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд судалгаа, тайлан боловсруулах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаас зайлсхийж, ажлын төсөвт өртгийг тооцоо судалгаанд үндэслээгүй харилцан адилгүй төлөвлөж, шууд болон харьцуулалтын аргаар гүйцэтгүүлэхээр тусган төлөвлөж, гүйцэтгэлээр 556,180,000.00 /Таван зуун тавин зургаан сая нэг зуун наян мянган/ төгрөгийн 12 гэрээ байгуулсан. Бодлого тодорхойлох аливаа арга хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг эрэмбэлж, хүрэх үр дүнтэй уялдуулан төсөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх";, 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх";, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Бодлого тодорхойлох аливаа арга хэмжээнд шаардлагатай судалгааны ажлуудыг эрэмбэлж, хүрэх үр дүнтэй уялдуулан төсөвлөж, зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-14.Docx

1526180294



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 116/АДТ/238

Улаанбаатар хот

САТ-2026/304/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" судлагааны ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод програм хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байж болно гэж тусган судалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэггүй, ажлын туршлагад судалгаа шинжилгээний ажил хийж байгаагүй байгууллагыг сонгон шалгаруулж, 80,000,000.00 /Наян сая/ төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гүйцэтгэгчээс хүлээн авсан судалгааны ажлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ашиглаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т "бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:" 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх;" гэж заасантай нийцэхгүй байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний туршлагатай байх шаардлага хангасан байгууллагыг сонгон шалгаруулж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 117/АДТ/238

Улаанбаатар хот

САГ-2026/304) ИА-СГА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангилалыг тогтоогоогүй байгаагаас худалдан авалтыг тодорхойлох боломжгүй өндөр зардал гарах эрсдэлтэй байна.

Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д "Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангилалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоох асуудлыг 2026 онд багтаан шийдвэрлэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 118/АДИ-Т1238

Улаанбаатар хот

САГ-2026/304/НА-СТА-Т143

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан оны эхэнд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж төсвийн жилийн дундуур улсын төсвийн зарцуулалтыг хумиж, төсөв татагдахад төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжээгүй байх, тайлант оны гүйцэтгэл хангагдахгүй байх нөхцөл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ" 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 48 дугаар зүйлийн 48.2.1-т "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Батлагдсан төсвийн хүрээнд, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд, хариуцлагатай зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Мягмарнаран), ахлах нягтлан бодогч (О.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН